

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ  
2024 ОНЫ ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 8 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН  
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ЭЭЛЖИТ БУС ЧУУЛГАНЫ ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН  
АГУУЛГА**

*2024 оны 8 дугаар сарын 23-ны өдөр, Баасан гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4 - 25
<i>1. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах</i>	6 - 25

---

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны 8 дугаар сарын 23-ны өдөр  
/Баасан гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 16 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.*

*Чөлөөтэй: Ж.Алдаржавхлан, Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, С.Одонтуяа, Б.Пүрэвдорж;*

*Тасалсан: Х.Баттулга, Д.Ганбат.*

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин үг хэлэв.

***Нэг. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Э.Золзаяа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Энэбишийн Золзаяагийн танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын Б.Бат-Эрдэнэ, Х.Тэмүүжин, Ц.Сандаг-Очир, Х.Баасанжаргал, С.Эрдэнэболд нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг, Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Э.Золзаяа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, С.Эрдэнэболд, Х.Тэмүүжин, Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчидтэй танилцлаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 1 цаг 14 минут үргэлжилж, 22 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 68.2 хувийн ирцтэйгээр 10 цаг 30 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**

ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ДАРГА

Д.ЦОГТБААТАР

**Тэмдэглэл хөтөлсөн:**

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

---

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 8 дугаар сарын 23-ны өдөр, Баасан гараг  
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим  
09 цаг 16 минут

### ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Цогтбаатар:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг дэвшүүлж.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Хууль зүйн байнгын хорооны 2024 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7.8-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Байнгын хорооны хуралдааны ирцийг одоо танилцуулна. Сая гишүүд бас нэмээд орж ирсэн шүү дээ. Тэд нарыгаа энэ дээр заасан байгаа. Дамдины Цогтбаатар, Энхтайваны Бат-Амгалан, Хүрэлбаатарын Баасанжаргал, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Мөнхтөрийн Нарантуяа, Одсүрэнгийн Номинчимэг, Ухнаагийн Отгонбаяр, Цэндийн Сандаг-Очир, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Гончигдоржийн Уянгахишиг, Даваагийн Цогтбаатар, Сүхбаатарын Эрдэнэболд гэсэн гишүүдийн ирцтэйгээр ирц бүрдсэн байна.

Ирц 54.5 хувьтай байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудал. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн Улсын дээд

шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн танилцуулга.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан асуулт асуух, саналтай гишүүд байна уу? Нэрсээ өгнө үү.

Үгүй үгүй. Одоо хэлэлцэх асуудалтай холбоотой. Х.Тэмүүжин гишүүнээр тасаллаа. Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

**Х.Тэмүүжин:** Улсын дээд шүүх болон Үндсэн хуулийн цэц гэх мэтчилэн байгууллагуудад томилогдож байгаа хүмүүстэй холбоотой нээлттэй сонголт зохион байгуулах хуулийн зохицуулалтыг Үндсэн хуулийн цэцээс хүчингүй болгочихсон.

Тийм учраас Улсын Их Хурал дээр яг энэ томилогдож байгаа хүмүүстэй холбоотой мэдээллийг нарийвчилж үзэх боломж жоохон хомс болсон.

Тэгээд сая ээлжит бус чуулган гэнэт зарлагдаад ээлжит бус чуулганы хэлэлцэх асуудал дотор ороогүй мөртөө гэнэт орж ирээд одоо гишүүдэд өчигдөр л материал гарсан байх.

Би өчигдрөөс хойш нэгэнт нь Дээд шүүхийн шүүгчийг томилох гэж байгаа учраас өмнө нь шийдвэрлэсэн шийдвэртэй холбоотой асуудлыг нь унших гээд Шүүхийн шийдвэрийн

нэгдсэн сан дотор хайх гэж оролдоод өнөөдөр харамсалтай нь тэр нь гацаад ажиллахгүй байна.

Тэгээд би мэдээлэл гүйцэт ерөөсөө авч чадсангүй. Тэр хүнтэй холбоотой урьд өмнө ямар маргаан шийдэж байсан юм, маргаантай нь холбоотой ямар маргаан гарч байсан юм гэх мэтчилэн түүхийг нь жоохон судлах гэж оролдсон. Яадсангүй.

Өчигдөр файлаар ийм дэлгэрэнгүй байгаагүй. Их цомхон байсан. Сая нэлээн зузаан цаас энэ ширээн дээр тавигдаж байна.

Тэгээд би асуух гээд байгаа нь юу вэ гэхээр дэг дээр чинь одоо ер нь юу гэж байна.

Өмнө нь ээлжит бусаар яг ийм томилгоотой холбоотой асуудлуудыг шийдэж байсан туршлага хэр зэрэг олон байна? Тохиолдол хэр зэрэг олон байна?

Хэрвээ ээлжит бус зарлагдаагүй байсан бол энэ ингэж орж ирэх юм уу? Ээлжит дээр л орж ирнэ шүү дээ. Тийм ээ.

Тэгээд энэ талаарх мэдээлэл байна уу, үгүй юу? Тэрийг л асуух гээд байгаа юм.

**Д.Цогтбаатар:** Тэгэхээр түрүүний хуралдаан дээр бас хэлэлцэх асуудал дээр энэ асуудал нэг яригдаад бас бүрэн гүйцэд нөхцөл бүрдээгүй байна гээд би нэг удаа хойшлуулсан байгаа.

Энэ асуудал бол Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 8 сарын 08-нд байсан байх. Энэ чинь нөгөө процесс эхлэнгүүт автомат яваад эхэлж байгаа процесс байхгүй юу.

Юу гэвэл 8 сарын 08-нд байх аа. Одоо яг би өдрийг нь санахгүй байна. Ерөнхийлөгчид энэ юугаа мэдүүлчихсэн.

Түүний хажуугаар параллель шууд Их Хуралд энэ асуудлаа тавьчихсан байж байгаа юм.

Асуудал тавингуут Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу, 106.2-ын дагуу энэ чинь автомат процесс эхэлчхэж байгаа байхгүй юу.

Энд бүр тодорхой заачихсан байгаа. Чуулган эхлээгүй байх үед ойрын хамгийн эхний чуулганаар 5 хоногийн дотор хэлэлцэнэ гэж байгаа юм.

Ээлжит бус чуулган эхэлчихсэн байгаа бол 5 хоногийн дотроо гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл аль альныг нь заачихсан байж байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ бол Их Хурлын даргын нөгөө уншиж танилцуулж байсан бидний хэлэлцэх асуудал байна шүү дээ.

Түүнээс тусдаа явж байгаа бөгөөд энэ давхар ороод ирж байгаа бол энэ дэгийн тухай хуулийнхаа дагуу бид 5 хоногийн дотор хэлэлцэхээс өөр ямар ч сонголтгүй асуудал байж байгаа юм.

Тийм учраас л энэ асуудал орж ирж байгаа юм.

Тэгээд танилцуулга эд нар нь харин цаг хугацаандаа бас гишүүдэд өгөөгүй байгаа бол манай ажлын алба үүнийг бас анхаарна биз.

Тэгээд энэ юмтайгаа танилцаж байх боломжийг гишүүдэд олгож байх ёстой.

Миний хувьд ч гэсэн энэ яг өчигдөр. Та нар санаж байгаа байх түрүүчийн хурал дээр би хойшлуулсан.

Өчигдөр над дээр үүнийгээ хугацаандаа хийхгүй бол болохгүй байна гэдэг асуудал орж ирсэн. Тэгээд л зарлаад хуралдуулж байгаа.

---

## Нэг.Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулах

---

Ингээд асуудалдаа орёе. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн танилцуулгыг танилцуулна.

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Энэбишийн Золзаяагийн танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Лхагвадоржийн Энхбилэг танилцуулна.

Ажлын хэсгийг оруулъя. Л.Энхбилэг дарга, Э.Золзаяа шүүгч.

2 дугаар микрофоныг өгье. Л.Энхбилэг дарга шууд танилцуулаад явчих.

**Л.Энхбилэг:** Хуралдаан даргалагч, гишүүддээ энэ өглөөний амар амгаланг айлтгая.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Л.Энхбилэг.

Өнөөдрийн хуралдаанд дараах асуудлыг танилцуулахаар орж ирлээ.

Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн танилцуулга.

Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд

танилцуулснаар Ерөнхийлөгч томилно гэж, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулснаар томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ гэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.2 дахь хэсэгт нэр дэвшигчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн байнгын хороо болон нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж тус тус заасан.

Үүний дагуу Улсын дээд шүүхийн шүүгчийн сул орон тоо нь сонгон шалгаруулалтын нөөцийн оноогоор нэгдүгээрт эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Энэбишийн Золзаяаг Хууль зүйн байнгын хорооны уралдаанд танилцуулж байна.

Нэр дэвшигчийн ерөнхий танилцуулгыг хийе.

Нэр дэвшигч Энэбишийн Золзаяа 1970 онд Улаанбаатар хотод төрсөн. 54 настай. Эмэгтэй. Ам бүл 4.

1978-1988 онд Нийслэлийн 18 дугаар сургууль, 1988-1994 онд Оросын Холбооны Улс, Москва хот дахь Нийтийн ахуй үйлчилгээний улсын академийн

инженер, техникийн ухааны магистр, 1996-1999 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, эрх зүйч бакалавр, 2009-2016 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, хууль зүйн ухааны магистр зэргийг тус тус хамгаалсан. Эрх зүйч мэргэжилтэй.

1999-2004 онд Нийслэлийн шүүхийн Тамгын газарт Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, 2004-2006 онд Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгч, 2006-2013 онд Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч, 2013-2014 онд Дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн нэгдүгээр шүүхийн шүүгч, 2014-2015 онд Иргэний хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч, 2015 оноос Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчээр ажиллаж байна.

Нэр дэвшигч Э.Золзаяа төрийн албанд 24 жил 7 сар, шүүгчээр 19 жил 9 сар. Үүнээс давж заалдах шатны шүүхийн шүүгчээр 9 жил ажиллаж байна.

Хуульд заасан шалгуурыг хангасан.

Нэр дэвшигч Э.Золзаяа Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан хяналтын шатны шүүхийн шүүгчид тавих болзол шаардлагыг дараах байдлаар хангасан.

Хууль зүйн дээд боловсролтой. 35 нас хүрсэн. Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй. Нэр дэвших үедээ яллагдагчаар татагдаагүй. Шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болох нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон.

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны эрхлэх зөвшөөрөлтэй.

Шүүгчээр жиллах мэдлэг ур чадвар, ёс зүйтэй.

Хууль зүйн мэдлэг чадварын шалгалтад 54.54 оноо, мэргэжил ёс зүй, зан төлөвийн шалгалтад 22.17. Нийт 76.71 гэсэн оноогоор нөөцөөс нэгдүгээрт эрэмбэлэгдсэн.

Шүүхийн тухай хуулийн Улсын дээд шүүхэд шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан байх шаардлагыг хангасан. Нийт 19 жил 7 сар ажилласан.

Сүүлийн 6 жил улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн гуравны хоёроос доошгүй нь шүүгч байна гэсэн энэ шалгуурыг хангаж байгаа.

Ингээд сонгон шалгаруулалтад тэнцсэн.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 173 дугаар тогтоолоор эрэмбэлэгдсэн оноо батлагдсан байгаа.

Ингээд Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар бичгээр гарсан хүсэлтийн дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.8, 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, сонгон шалгаруулах журмын 9.4-д заасныг баримтлан Улсын Дээд шүүхийн сул



орон тооны сонгон шалгаруулалтад эрэмбэлэгдэж, нөөцийн оноогоор нэгдүгээрт жагссан Хяналтын шатын шүүхийн шүүгчийн нөөцийн оноотой нэр дэвшигчээс нэгдүгээрт эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Энэбишийн Золзаяаг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилуулах саналыг Их Хуралд Та бүхэнд танилцуулж байна.

Танилцуулга дууслаа. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Нэр дэвшигчийн танилцуулгыг гишүүдэд тараасан байгаа.

Тэгэхээр танилцуулгатай холбогдуулан нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү?

Ц.Сандаг-Очир гишүүнээр. Байж байгаарай. Х.Баасанжаргал гишүүн гишүүнээр тасаллаа. С.Эрдэнэболд гишүүнээр тасаллаа. Б.Бат-Эрдэнэ гишүүний микрофоныг өгье.

**Б.Бат-Эрдэнэ:** Э.Золзаяадаа амжилт хүсье.

Хэд хэдэн асуулт байна. Сонгон шалгаруулалтад тэнцсэн байдал дээр оноо мэргэжил, ёс зүй, зан төлөвийн шалгалт 22.17 гээд. Энэ одоо хэдэн оноо байх ёстойгоос ийм оноо авдаг юм бол гэдгийг бас нэгдүгээрт мэдмээр байна.

Гол асуух асуулт маань Монгол Улсын шүүхийн тухай хууль гэж бий.

Шүүхийн тухай хуулийн 17.1.3 хуульд өөрөөр заагаагүй бол шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрээ албажуулах буюу ерөнхий шүүгчийн бүрэн эрхтэй холбоотой асуудал байдаг.

Энэ дээр харахаар шүүх бүрэлдэхүүнийг томилох, эсвэл бүрэлдэхүүнийг өөрчлөх тухай шийдвэрийг албажуулах ерөнхий шүүгчийн эрх нь ганц хүний шийдвэр байх нь одоо хэр эрсдэлтэй байдаг вэ гэдэг нэг асуулт байна.

Хоёрдугаар асуулт нь, хуулийн 25.8.5 дугаар зүйл. Үндсэн хуулийн цэц бол Ерөнхий прокуророос шилжүүлэх асуудалтай холбоотой байдаг.

Энэ бол 25.8.5 дээр хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц Улсын Ерөнхий прокурорт шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх гэдэг ийм заалттай л даа.

Тэгээд энэ ямар асуудлыг хянан шийдвэрлэх эрхтэйг нь тодорхой болгох нь илүү зүйтэй юм болов уу гэж боддог. Тэгээд энэ дээр та ямар саналтай байдаг вэ?

Гуравдугаар асуулт нь, энэ 2024-2028 оны Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр шүүх засаглалтай холбоотой 4.1.6.5 дээр Хуульчдын холбоог шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн холбоо болон бусад хуульчдын холбооны гишүүнчлэлтэй гишүүддээ үйлчилдэг мэргэжлийн холбоо байхаар өөрчлөн зохион байгуулна гэдэг ийм заалт Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр дээр орчихсон байдаг л даа.

Үүнийг хасчихсан байгаа юу? Тийм ээ. Ойлголоо.

Тэгвэл сүүлийн асуулт нь, ер нь тухайн улсын Ерөнхийлөгчтэй холбоотой дандаа энэ асуудлууд үүсдэг. Шүүгч томилгоотой холбоотой асуудал дээр.

Тэр Ерөнхийлөгчийн үед томилогдсон шүүгч, энэ Ерөнхийлөгчийн үед томилогдсон шүүгч гэж их яригддаг л даа.

Тэгээд ер нь зүгээр энэ шүүгчийг томилох Ерөнхийлөгчийн эрхийг эргэж харах ёстой юу? Энэ дээр та одоо бас томилогдож байгаа хүний хувьд ямар бодолтой байдаг вэ гэсэн ийм асуултуудыг асууя.

**Д.Цогтбаатар:** Шүүгчээс шууд өөрөөс нь асууж байна гэж ойлгох уу? Тийм ээ. Тэгвэл 3 дугаар микрофон л өгье.

**Э.Золзаяа:** Хуралдаан даргалагч болон гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Нэр дэвшигч Энэбишийн Золзаяа байна.

Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Сонгон шалгаруулалтын мэдлэг, ёс зүйн шалгалт байгаа. Энэ шалгалт нь 30 хүртэлх оноотой.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүд шалгалт авдаг. Хуулийнхаа дагуу гишүүдийн тавьсан оноо байгаа. Эхний асуултын хүрээнд ийм хариулт өгье дөө.

Хоёр дахь асуултад. Шүүхийн тухай хууль дээр заасан хэрэг маргааныг хуваарилахтай холбоотой, хуваарилагдсан хэрэг маргааныг Ерөнхий шүүгч захирамжаар баталгаажуулахтай холбоотой асуудлыг тавьсан байна.

Гурван процессын хуульд байгаа. Гурван процессын хуульд шүүгчдийн зөвлөгөөнөөс шүүгчдийн шүүхийн шүүгчид хуваарилагдах хэрэг маргааныг хэрхэн хуваарилах вэ гэдгийг зөвлөгөөн тухай бүрд нь шийдвэрлэдэг.

Хуульд орсон заалтын дагуу санамсаргүй байдлаар, тохиолдлын журмаар хуваарилагдана гэж заасан байгаа.

Үүнийг шүүгчдийн зөвлөгөөнөөр янз бүрээр шийддэг.

Манай Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатын шүүх хэрхэн шийдвэрлэсэн бэ гэх юм бол шүүгчдийн зөвлөгөөн жил бүр энэ журмаа тогтоодог.

Тэгэхээр энэ журам нээлттэй шүүхүүдийн цахим хаягт байршсан байгаа. Тэндээс олоод мэдэж болно.

Хэрхэн хуваарилдаг талаар санамсаргүй тохиолдлын гэхээр бид сугалаагаар нэг явуулах нэг боломжтой. Тухай бүрд нь тодорхой бүрэлдэхүүн томилж шийдвэрлэх ийм боломжтой байдаг. Үүнийг Захиргааны хэргийн давж заалдах шатын шүүх олон жил хэрэгжүүлсэн. Анх удаа манайх 2024 оны шүүгчдийн зөвлөгөөнөөр бүрэлдэхүүнтэй байхаар ингэж шийдвэрлэсэн байгаа юм.

Тэгэхээр шүүгчдийн зөвлөгөөний эрх хэмжээний асуудал байгаа юм. Харин Шүүгчдийн зөвлөгөөний энэ эрх хэмжээний асуудлын хүрээнд шийдвэрлэгдсэн хэргийг ерөнхий шүүгч баталгаажуулсан ийм захирамж гаргадаг.

Энэ ямар учиртай юм бэ гэхээр бид шүүх бүрэн цахимжаагүй байгаа. Бүрэн цахимжсан тохиолдолд

зөвлөгөөнийхөө тогтоолыг хэлээд тэнд анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхэд хэн хуваарилагдсан бэ гэдгийг хэрвээ бүрэн цахимжсан тохиолдолд хэн ч олоод харах боломжтой байдаг.

Ийм боломжгүй байгаа тохиолдолд хэргийг зөв хүн шийдэх ёстой гэдэг энэ зарчмынхаа дагуу шүүгчдийн зөвлөгөөнөөр яг хуваарилагдсан шүүгч нь шийдэж байна уу гэдгийг хянах ганц боломж нь энэ цаасан хэлбэрээр гарч байгаа ерөнхий шүүгчийн энэ баталгаажуулах захирамж байгаа юм.

Тэгэхээр Ерөнхий шүүгч дураараа хэргийг хэн нэгэн этгээдэд хуваарилахгүй байгаа.

Тэгэхээр шүүгчдийн зөвлөгөөнөөр тогтоосон журмын дагуу хуваарилагдсан бүрэлдэхүүнийг л баталгаажуулж, дараа дараагийн шатан дээр нь процессын зөрчил гарч уу гэдгийг хянах үүднээс энэ захирамжийг хэрэгт үдэж явуулж байгаа. Ийм хариулт өгье дөө.

Шүүхийн тухай хуулийн 25.2. Тэр Үндсэн хуулийн цэц болон прокуророос шилжүүлсэн хүний эрхтэй холбоотой асуудлыг Улсын дээд шүүхэд шийдвэрлүүлэхээр шилжүүлж байгаа ийм заалт ерөнхий байдлаар зохицуулчихсан байгаад байгаа.

Тэгэхээр энэ асуудлаар харин хэрхэн шүүх шийдвэр гаргах вэ гэдэг ийм процедурын асуудал байхгүй байгаа.

Тэгэхээр хүний эрх зөрчжээ гэхээр Улсын Дээд шүүх ямар чиг үүрэг.../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** 3 дугаар микрофоныг өгье. Гүйцээж хариулъя.

**Э.Золзаяа:** Давж заалдах шатын шүүхийн гарсан магадлалыг хянадаг ийм чиг үүрэгтэй байгаа.

Энэ шилжүүлж ирж байгаа өргөдөл, гомдол нь хэрэг маргаанд хамааралгүй, хяналтын журмаар гаргасан гомдолд огт хамаарахгүй байх юм бол энэ ямар асуудлыг шийдвэрлэх вэ гэдгийг маш тодорхой болгож өгөх ёстой.

Тэгэхээр өөрөөр хэлбэл шилжүүлэх гээд байгаа юм уу. Тийм ээ. Прокурорын асуудал байх юм бол прокурорт нь шилжүүлэх гээд байгаа юм уу, анхан шатын шүүх дээр хэрэг маргаан байгаа юм бол тийш нь шилжүүлэх гээд байгаа юм уу гэдэг энэ асуудлуудыг нь маш тодорхой болгож өгөх ёстой гэдэг л байр сууриа илэрхийлье дээ.

Ерөнхийлөгчийн хувьд шүүгчийн томилгоог хийж байгаа. Миний бодлыг л асуусан гэж. Тийм ээ. Хувийн бодлыг асуусан гэж ойлгож байна.

Ерөнхийлөгч шүүгчийг томилж байгаа. Энэ бол хуулийнхаа дагуу хийж байгаа ажил. Хуулийг Улсын Их Хурал баталдаг. Одоо энэ үзэл баримтлалынхаа хүрээнд л энэ хүн энэ ажлаа албан тушаалынхаа хүрээнд эрхэлж байгаа гэж бодож байгаа.

Хэр зохимжтой вэ гэхээр Ерөнхийлөгчид өгсөн энэ үзэл баримтлалын хүрээнд Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийг шилж сонгож байгаа. Ерөнхийлөгч хэдхэн заалтын хүрээнд л энэ зарлиг гаргах уу, үгүй юу гэдэг асуудлыг шийдвэрлэдэг болохоос ерөнхийдөө Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шилж сонгосон шүүгчдийг Ерөнхийлөгч

хуульд заасан үндэслэлээр татгалзал байхгүй л томилж байгаа.

Тэгэхээр хувийн байр суурины үүднээс хандахгүй байх гэж бодож байгаа. Одоо хуулийн л үзэл баримтлалын хүрээнд. Нэг ёсны нөгөө хяналт хэрэгжүүлж байгаа л гэдэг агуулгаар.

**Д.Цогтбаатар:** Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

**Х.Тэмүүжин:** Надад хоёр л асуулт байна.

Шүүхийн ерөнхий зөвлөл нэр дэвшигч хоёр. Гэхдээ эхнийх нь энэ хоёроос бараг асуугдаж байгаа асуулт шүү.

Дээд шүүх бусад шүүхээсээ ялгаатай нь бараг онолын маягтай шүүх. Хууль зүйн хувьд одоо президент тогтоож, доод шатны шүүхүүдэд хэрэг маргаанаа хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэдэг хуулийн тайлбарыг нь бараг хийх хэмжээний эрх мэдэлтэй.

Гэхдээ энэ хууль тайлбарлах тухай ерөөсөө яриа биш.

Үндсэн хууль дээр хуулийг хэрхэн зөв хэрэглэх талаарх албан ёсны тайлбарыг гаргана гэсэн агуулгатай байж байгаа.

Манай Дээд шүүх урьд нь бид хууль тайлбарладаг гэдэг тийм ташуу хандлагатай. Тэрийгээ хамгаалуулахын тулд Үндсэн хуулийн цэцэд хүртэл гомдол гаргаж байсан түүхтэй.

Би Улсын Их Хурлыг төлөөлж тэр маргаанд 2 удаа очиж байснаа санаж байна.

Тийм учраас одоо би Дээд шүүхийн шүүгч болох гэж байгаа хүнээс байр суурийг нь асууж байгаа юм. Та хэд хууль тайлбарлахаас илүүтэй хуулийн хэрэглээний тайлбарыг гаргах ёстой. Хуулийн хэрэглээний тайлбар академик байдлаар гарч ерөөсөө болохгүй.

Хэрэг маргааныг тодорхой кэйсийг шийдэх явцтай гарч байх ёстой. Хэргээс гадуур гаргаж байгаа тайлбар бол хууль тогтоох эрх мэдлийг булаацалдаж байгаа гэж бусад улс оронд үзэгддэг.

Тийм учраас Дээд шүүх, Улсын Их Хурал хоёр аль нь хууль тогтоогоод байна гэдэг маргаан хүртэл Үндсэн хуулийн түвшинд явдаг учраас энэ дээр бас болгоомжтой хандах ёстой байх.

Хувийн байр сууриуд болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн байр суурь ямар байгаа гэдгийг асуумаар байна.

Хоёр дахь нь, дэлхийн шүүхийн тогтолцоонд хуулийнхаа хувьд, утга агуулгынхаа хувьд тогтсон хоёр зарчим байгаа.

Нэг нь, энэ улс төрийн асуудлууд буюу бодлогын шийдвэрийг шүүх авч хэлэлцэхгүй гэдэг нэг ийм зарчим байдаг.

Хүүхдүүдэд тэтгэлэг өгөх үү, үгүй юу гэдэг бол улс төрийн шийдвэр. Яаж өгч байгаа юм гэдэг нь хууль зүйн шударга ёсны асуудал байдаг.

Манай шүүх нэг бус удаа улс төрийн шийдвэрийг авч хэлэлцэх гэж оролдсон тохиолдлууд гарсан.

Тэр дундаа Засгийн газрын хамтын шийдвэрүүд шүүх дээр гэмт хэрэг гэдэг байдлаар хэлэлцэгдэх тохиолдлууд хэд хэдэн гарсан.

Энэ дээр ямар байр суурьтай байна гэдгийг би асуухыг хүсэж байна.

Яг үүнтэйгээ холбоотой бас хоёр дахь зарчим. Шинжлэх ухааныг шүүхгүй гэдэг зарчим бас байдаг. Академик түвшний маргаан шинжлэх ухааны буюу академик түвшиндээ шийдвэрлэгдэх ёстой.

Шүүх дээр аль нь хоцрогдсон, аль нь хууль ёсных вэ гэх мэтчилэн ийм академик эрх чөлөө хязгаарласан маргааныг огт шийдвэрлэж болохгүй гэдэг зарчим үйлчилдэг. Шүүх дээр.

Монгол Улсад үүнийг эвдсэн нэг удаагийн кэйс гарсан. Дэлхийд хоёрхон кэйс байдаг.

Нэг нь Италид байдаг, нэг нь Монголд байдаг.

Сүхбаатар дүүргийн шүүхээс гарч байсан. Хоцрогдсон хоцрогдоогүй буюу шинжлэх ухааны үндэслэлтэй маргаануудыг шүүх авч хэлэлцсэн тохиолдол байдаг. Энэ дээрх байр суурийг сонсмоор санагдаж байна.

**Д.Цогтбаатар:** Шүүхийн ерөнхий зөвлөлөөс эхлээд хариулаад явъя.

**Л.Энхбилэг:** Х.Тэмүүжин гишүүний асуултад хариулъя.

2021 оны 3 сараас хэрэгжээд байгаа энэ хуулийн хэрэгжилтээр Улсын дээд шүүх хууль хэрэглээний нэгдмэл

байдлыг хангах ийм байр суурьтайгаар ажиллаж байгаа.

Яг тухайлаад янз бүрийн хэрэг маргааны асуудал дээр Ерөнхий зөвлөл оролцох боломжгүй. Шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр хүний нөөцийн бодлого, санхүү, хөрөнгө оруулалт, шүүгчийг шилж олох тэр чиг үүргийнхээ хүрээнд ажиллаж байна.

Бидний хувьд Улсын дээд шүүхтэйгээ хамтраад шүүгчийн сургалтыг явуулдаг байсан.

Сая энэ хаврын чуулганы хуулийн өөрчлөлтөөр шүүгчийн сургалт Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академид очсон. Одоо бол Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн захиргааны албан хаагчдынхаа сургалтыг хариуцаж байгаа.

Тэгэхээр Улсын Дээд шүүхийн дэргэдэх академи бол энэ хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах энэ чиг үүргээрээ шүүгч нартаа сургалтаа явуулж байгаа.

Ер нь шүүгч нарт яг энэ хуулийн хэрэглээ, практик бүх талын судалгааг Улсын Дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн академи явуулж байгаа. Хөтөлбөрийн хороо гэж байдаг. Тэндээ тэр сургалтынхаа хөтөлбөрийг батлаад, саналаа аваад явдаг. Мөн сургагч багш нарыгаа бас тэндээ бэлтгэдэг ийм байгаа. Товчхондоо хариулахад.

**Д.Цогтбаатар:** Э.Золзаяа шүүгчийн микрофоныг өгье.

**Э.Золзаяа:** Х.Тэмүүжин гишүүний эхний асуултад хариулъя.

Өөрөөр хэлбэл Улсын дээд шүүхийн тайлбар гаргахтай холбоотой.

2013 оны шүүхийн тухай хуулиар 2012 онд баталсан, 2013 онд хэрэгжиж эхэлсэн Шүүхийн тухай хуулиар хууль хэрэглээг хэрэг маргааныг шийдвэрлэх замаар хуулийн хэрэглээний тайлбар гаргана гэдэг ийм заалт орж ирж байсан.

Энэ заалт Үндсэн хуулийн цэцээр унаж байсан. Одоо хүчин төгөлдөр байгаа заалтын хүрээнд Үндсэн хуульд зааснаар Улсын Дээд шүүх тайлбар гаргаж байгаа.

Мөн Шүүхийн тухай хуульд зааснаар тайлбар гаргаж байгаа.

Улсын дээд шүүхийн тайлбаруудыг харах юм бол Х.Тэмүүжин гишүүний яг ажигласнаар байгаа.

Өмнө нь хууль тайлбарлахдаа тухайн зүйл, заалтад байгаа ийм нэр томъёоны зөрүүтэй, нэр томъёоны ойлгомжгүй заалтуудыг ингэж ойлгоно гэдэг ийм тайлбар гарч байсан бол одоо сүүлийн үед гарч байгаа тайлбарыг харах юм бол эрэлт хэрэгцээ, шаардлага гарч байна.

Эрэлт хэрэгцээ, шаардлага дээр ийм ийм онолын асуудлууд байдаг юм байна. Ийм ийм онолын асуудлын хүрээнд энэ тайлбарыг хийх нь зүйтэй гэдэг ийм агуулгаар тайлбар гарч байгаа.

Тэгэхээр Улсын дээд шүүх тайлбар хийх нь хуульд нь заасан ажиллагаа, хуульд нь заасан үүрэг байгаа юм.

Хоёр дахь асуудлын хүрээнд академик эрх чөлөөний асуудлаар шийдвэр гаргаж болохгүй гэдэг энэ

шүүмжлэлтэй хандаж байгаа асуудалд анхааралтай, болгоомжтой хандаж энэ асуудлыг Х.Тэмүүжин гишүүний хэлснээр академик эрх чөлөөний асуудлаар шийдвэр гаргаж болохгүй юм байна. Энэ асуудал дээр цаашид анхаарч, судалж, дэлхий нийтэд гарсан.../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Микрофоныг гүйцээж өгөөд, хариултыг гүйцээж явъя.

**Э.Золзаяа:** Дэмжигдэхгүй байгаа тэр Италийн гэж ярьж байгаа энэ шийдвэрүүдийг судалж, цаашид ийм алдаа гаргахгүй байх тал дээр анхаарч ажиллана.

Шүүх маань ардчилсан нийгэм, зах зээлд шилжээд 30 гаруй жил болж байна. Алдаа оноо байхыг үгүйсгэхгүй. Бид бүгд л сурч явж байна.

Алдаа гаргахгүй тал дээр л бид бүгд аль алиндаа хичээж л ажиллах хэрэгтэй л гэж үзэж байна.

**Д.Цогтбаатар:** Тэр юуны талаар асуусан шүү дээ.

Улс төрийн шийдвэрийн талаар. Ялангуяа хамтын шийдвэр.

**Э.Золзаяа:** Улс төрийн бодлогын шийдвэрийн агуулгын хувьд болохоор шүүх хянахгүй.

Процессын хувьд болохоор шүүх хяналтаа хэрэгжүүлэх ёстой. Жишээлбэл, тендерт орж байгаа хүмүүсийн шалгаруулах процедур байгаа. Процедурын алдаа гаргаж байна уу, үгүй юу гэдэг бол яалт ч үгүй шүүхийн хянах асуудалд хамаарна гэж үзэж байна.

Харин бодлогын шийдвэрийн агуулгад хяналт тавих нь зохимжгүй гэж бодож байгаа.

**Д.Цогтбаатар:** Ц.Сандаг-Очир гишүүний микрофоныг өгье.

**Ц.Сандаг-Очир:** Шүүхийн ерөнхий зөвлөлөөс асууя.

Э.Золзаяа шүүгч хүний нөөцөөс нэгээр эрэмбэлэгдэж гарч ирсэн гэж байна.

Хүний нөөцөд хэдэн хүн эрэмбэлэгдэж байгаа вэ? Нөөцөд шүүгч нар ер нь Дээд шүүх рүү, давхар луу ажиллах хүсэл сонирхол хэр байна вэ?

Энэ дээр нэг хариулт өгөөч.

Хоёрт, Э.Золзаяа шүүгч Сахилгын хороонд дуудагдаж байсан уу? Ёс зүйн ямар нэг зөрчил дутагдал гаргаж байсан уу?

Гуравт, 2022 оны 3 сарын 01-нээс Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж хэрэгжээд даруй 3 гаруй жил өнгөрч байна.

Энэ хуулийн хүрээнд энэ хуулиар олгогдсон эрх зүйн хүрээнд Та өнөөдөр бас ингэж нэр дэвших бололцоо боломжтой болж байгаа. Өмнө нь үе үеийн Ерөнхийлөгч нар орж ирээд л батлаад л ингээд л явчихдаг байсан бол өнөөдөр шинэ хуулийн хүрээнд ингэж орж ирж хэлэлцэгдэж, бүр бид нар чинь нийтийн хяналтын сонсгол ч хүртэл хийж байсан байх. Ийм байсан.

Тийм учраас цаашдаа энэ Шүүхийн тухай хууль ер нь алдаа оноо нь юу байна гэж үзэж байна. Та анхан шатан дээр ажиллаж байгаа хүний хувьд.

Үүнийг нэг ингээд засчих юмсан, энэ нь амьдралд хэрэгжихгүй байна, боломжгүй байна ч гэдэг юм уу. Та тэр дундаа иргэний хэргийн маргаан дээр ажилладаг шүүгчийн хувьд энэ шүүхийн хэрэг маргааны чинь дийлэнх олонх нь иргэний хэрэг маргаан байгаа шүү дээ.

Та нар одоо их ачаалал дунд ажиллаж байгаа. Тэндээс ирж байгаа улсуудын хувьд.

Шүүхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар цаашдаа алдааг нь ингээд нэг засчих юмсан гээд хувь хүний бодол юу байна.

Цаашдаа хэрвээ Дээд шүүхийн шүүгчээр томилогдвол шүүхийн салбарт хийе гэсэн шинэчлэл, өөрчлөлт юу байна? Шүүхийн шүүгчээ хийхээсээ гадна энэ салбарыг эрүүлжүүлэх, шударга байлгах, ил тод байлгах энэ тал дээр хувь хүний хувьд бодож явдаг байр сууриа бас хуваалцана уу гэж хэлье. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** 3 дугаар микрофон. Шүүхийн ерөнхий зөвлөл. 2 дугаар микрофон.

**Л.Энхбилэг:** Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. 2021 оны 3 дугаар сараас хойш хэрэгжсэн Шүүхийн тухай хуулиар Шүүхийн ерөнхий зөвлөл 2021 оны 12 сарын 09-нөөс хойш бүрэн бүрэлдэхүүнээр ажиллаж эхэлсэн.

Үүнд бид 8 удаагийн сонгон шалгаруулалтыг явуулаад, 9 дэх удаагийн сонгон шалгаруулалтын бүртгэлийн ажиллагаагаа товлоод явж байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 4 сарын 07-ны 87 дугаар тогтоолоор

Улсын дээд шүүхийн шүүгчийн 4 орон тоонд сонгон шалгаруулалт зарласан.

Нийтдээ 9 нэр дэвшигч материалаа ирүүлснээс 7-г нь бүртгэсэн. Шалгалт өгсөн 7, тэнцсэн 2 байгаа.

2 дахь сонгон шалгаруулалт бол шүүгчийн сул орон тоог нөхөх зорилгоор 2022 оны 6 сарын 10-ны өдөр 194 дүгээр тогтоолоор Улсын дээд шүүхийн 3 орон тоонд сонгон шалгаруулалт зарласан.

Нийт 9 нэр дэвшигч бүртгэгдсэн. Материалаа ирүүлсэн. 6 бүртгэгдсэн. Шалгалт өгсөн 6. Тэнцсэн 4 байгаа.

3 дахь нь 2023 оны 3 сарын 03-ны 82 дугаар Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоолоор Улсын дээд шүүхийн шүүгчийн нэг сул орон тоонд сонгон шалгаруулалт зарласан.

Нийт 2 нэр дэвшигчээс материал ирснийг 2 нэр дэвшигчийн материалыг бүртгэсэн. Шалгалт өгсөн нь 1. Тэнцсэн 1 байгаа.

Үүнтэй холбогдуулаад Улсын дээд шүүхэд Баярмаа, Батбаатар, Пүрэвсэн, Батзориг, Батчимэг гэсэн нэр дэвшигч нар шалгалтдаа тэнцэж, Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргасан байгаа.

Үүнтэй холбогдуулаад ер нь гишүүдэд нэг мэдээлэл өгөхөд нийтдээ анхан, давж заалдах, хяналтын шатын бүх шатын шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалт нь нийт 314 сул орон тоо давхардсан тоогоор зарлаж, 1153 нэр дэвшигчийн өргөдлийг хэлэлцэж, 888 нэр дэвшигчийг бүртгэж, 8 удаагийн сонгон шалгаруулалт зарласан.

Өнөөдрийн байдлаар 115 нэр дэвшигчийг Монгол Улсын

Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж, 104 шүүгч томилогдсон ийм тоон мэдээ байгаа. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** 3 дугаар микрофон.

**Э.Золжаргал:** Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Сахилгын хороонд өргөдөл гаргаж байсан уу гээд. Би биш л дээ нөгөө бусад хүмүүсээс. Тийм ээ.

Сахилгын хороонд өргөдөл гаргадаг. Сахилгын хороо шийдвэрлэдэг. Сахилгын хорооноос арга хэмжээ авагдаж байгаагүй. Тийм. Надад холбогдуулж гаргасан өргөдлийн хүрээд ирж байгаа.

Хэрэг маргаан шийдвэрлэхтэй холбоотой гомдол шүүгч болгон дээр шахуу л гардаг.

Тэгэхдээ их хэмжээтэй, бага хэмжээтэй юу гэдэг нь тухай бүрдээ Сахилгын хорооны тайланд тусгагдаж байгаа байх.

Миний хувьд сахилгын арга хэмжээ 20-иод жил энэ шүүгчээр ажиллахад авагдаж байгаагүй.

Шүүхийн тухай хууль 2021 онд батлагдсан. 2021 онд батлагдсан хуулийн дагуу энэ сонгон шалгаруулалтад оролцож байгаа.

Энэ оролцсон сонгон шалгаруулалт журмын дагуу нэлээн нарийвчлан зохицуулагдсан байгаа. Түүнчлэн сонгон шалгаруулалтын журмыг Ерөнхий зөвлөл нарийвчлан зохицуулж, алдаа оноогоо тухай бүрд нь



байгаа алдаа оноог засаж залруулж шинэчилж ирсэн байгаа.

Шүүхийн тухай хуультай холбоотой. 2021 оноос хэрэгжиж байгаа. Шүүхийн тухай хуулийн тухайлсан яг үүнийг засчихъя, тэрийг засчихъя гэдэг зүйл одоо толгойд шууд орж ирэхгүй байна.

Иргэний хэргийг дагнан шийдвэрлэдэг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль маань өөрөө иргэн нэхэмжлэлийг хүлээж аваад эцсийн байдлаар шийдвэр гаргах хүртэл энэ процедурыг зохицуулсан байгаа. 2002 оны хууль.

Эрүүгийн болон захиргааны процессын хуульд 2017 онд өөрчлөлт орсон байгаа. Энэ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дорвитой өөрчлөлт ороогүй байгаа.

Хэргийн ачааллыг бууруулахтай холбоотойгоор хийх өөрчлөлтүүд байгаа.

Одоо шууд хэлэхэд.../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Микрофоныг гүйцээгээд өгье. Хариултыг гүйцээж авъя.

**Э.Золзаяа:** Нэн түрүүн шаардлагатай хуулийн зохицуулалт юу гэхээр урьдчилсан шүүх хуралдаан гэдэг ийм зохицуулалтыг оруулж өгмөөр байна.

Урьдчилсан шүүх хуралдааны зохицуулалт ороод өгөх юм бол энэ шүүх хуралдаан олон удаа хойшилдог ийм байдлууд зогсох боломж байгаа.

Өөрөөр хэлбэл урьдчилсан шүүх хуралдаанаар талууд нотлох баримтаа бүрдүүлж аваад үндсэн хуралдаанд орох нотлох баримтын талаар тохирчихсон байдаг учраас дахиж ийм өөрчлөлт орохооргүй үндсэн шүүх хуралдаан шууд явагдах ийм боломжтой.

Гэтэл ийм зохицуулалт байхгүй байгаа учраас одоо хэргийн оролцогч талууд шүүх хуралдаан дээр хэргийн нотлох баримтыг шинээр авчирч өгөх байдлаар шүүх хуралдаан хойшилдог ийм нөхцөл байдлууд байгаа.

Тэгэхээр нэн ялангуяа хийх шаардлагатай Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд хийх шаардлагатай ийм өөрчлөлтийн хүрээнд урьдчилсан шүүх хуралдааныг хийж өгөөч ээ гэдэг юуг хэлж байна.

Тэгээд зөндөө олон нэхэмжлэлүүдийг гаргадаг болгооч ээ гээд зөндөө олон саналууд явна л даа. Тэр болгоныг одоо энд нурших боломжгүй байгаа учраас гол зүйлийг нь хэлчихье.

Шүүх дээр байгаа хэрэг маргааны тоог хэрхэн бууруулах вэ гэдэг тал дээр аль аль тал дээрээ авч үзэх юм бол энэ хэрэг маргаан шийдвэрлэх энэ сонголтот аргуудыг их хөгжүүлж өгмөөр байгаа юм.

Энэ сонголтот аргуудыг хөгжүүлээд өгөх юм бол харьцангуй шүүх дээр ирж бухимдаж байгаа асуудлууд нэлээн багасна гэж байгаа юм.

Эвлэрүүлэн зуучлал хөгжиж байгаа. Манайд тэгэхдээ бас эвлэрүүлэн зуучлалыг нэлээн хөгжүүлэхийн тулд тэр төлж байгаа тэмдэгтийн хураамж, шүүхэд төлж байгаа тэмдэгтийн хураамж хоёрын зааг ялгаа дээрээс хүмүүсийн сонирхлыг татах үүднээс бага байх. Аль хэмжээгээр

энэ тэмдэгтийн хураамжийн зөрүүг гаргаж байж л энэ маргаан шийдвэрлэх энэ эвлэрүүлэн зуучлал хөгжих байх. Илүү хөгжих байх. Ер нь нэлээн ачааллыг авч үүрч яваа л даа.

Тэгэхдээ бас хангалттай биш л гэж миний зүгээс бодож байгаа.

**Д.Цогтбаатар:** Х.Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

**Х.Баасанжаргал:** Надад хоёр асуулт байна.

Таны танилцуулгад ирсэн материалаас харахад 2022 оны 3 сарын 14-нөөс 2022 оны 10 сарын 27-ны хооронд Хуульчдын холбооны гишүүнчлэлийг түдгэлзүүлж байсан байна.

Тэгэхдээ яг үүнтэй холбоотой ер нь шүүгчид энэ Хуульчдын холбооны гишүүнчлэлээ маш их түдгэлзүүлдэг. Заавал байх албагүй гээд. Эсвэл татварын асуудал бас их яригддаг.

Тэгэхээр энэ дээр хувь хуульчийнхаа хувьд ямар байр суурьтай байдаг вэ гэдгийг нэгдүгээрт асууя.

Хоёрдугаарт, үндсэн эрхийн маргааныг Үндсэн хуулийн цэц шийдвэрлэх гэдэг бас их маргаантай асуудал байдаг.

Тэгэхээр энэ асуудал дээр бас хувь хүний хувьд ямар байр суурьтай байдаг вэ гэсэн ийм хоёр асуулт байна.

**Д.Цогтбаатар:** 3 дугаар микрофон өгье.

**Э.Золжаргал:** 2013 оны Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулиар шүүгч, прокурор, өмгөөлөгч гээд гурван хуульч мэргэжилтэй.

Энд хуульч мэргэжлийн гэрчилгээ авсан бусад хуульчид Монголын хуульчдын холбооны гишүүнчлэлтэй болсон. Сүүлд энэ шүүгч нар түдгэлзэж эхэлсэн.

Миний бие энэ холбооны гишүүний хувьд түдгэлзээгүй. Хуульчдын холбоонд идэвхтэй оролцдог, дэмждэг. Бас харьцангуй зөв чиглүүлэх энэ тал дээр хувь нэмэр байдаг юм болов уу гэж бодоод идэвхтэй оролцдогоо.

Би энэ Хуульчдын холбоонд Иргэний эрх зүйн хорооны удирдах зөвлөлд хоёр удаа ажиллаж байсан.

Хуульчийн мэргэжлийн хороонд гишүүн, даргаар нь ажиллаж байсан. Одоо энэ татан буугдчихсан хороо байгаа.

Одоо шалгалтын хороонд ажиллаж байгаа. Түүнчлэн Хуульчдын холбооны удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байгаа.

Мөн Шүүгчдийн хорооны удирдах зөвлөлд ажиллаж байгаа.

Хуульч гэдэг энэ мэргэжлийн нэр хүндийг өргөх, энэ хуульчийн мэргэжил нийгэмд хэрхэн хэчнээн их ач холбогдолтой талаарх, иргэд хуулийн зөвлөгөө авч чаддаг болох. Ийм чиглэл дээр өөрийн хувь нэмрийг оруулъя гэж бодож ажилладаг.

Тэгэхээр Хуульчдын холбооны гишүүнээс түдгэлзэж байгаагүй. Миний хувьд.

Шүүгч нар түдгэлзсэн байгаа. Хуульчдын холбоонд ажиллаж байгаа энэ гишүүд бол шүүгчид бас оролцоотой байгаасай гэж их хүсдэг.

Х.Баасанжаргал гишүүний хоёр дахь асуултад хариулья. Үндсэн эрхийн маргааны талаар асуулаа.

Сүүлд хүчтэй яригдаж байгаа нь негатив хяналтыг хэрэгжүүлдэг болъё гэсэн.

Энэ негатив хяналтыг хэрэгжүүлэхээр хуульд өөрчлөлт оруулах юм бол гурван шатны шүүхээр шийдвэрлэгдсэн маргаантай холбоотой хүний үндсэн эрхийн талаарх асуудал Үндсэн хуулийн цэцэд ирэх байх.

Тэгэхээр түрүүн хуралдаан даргалагчийн хэлснээр, би Д.Цогтбаатар гишүүний хэлснээр асуултаа ингээд дуусгая.

**Д.Цогтбаатар:** С.Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

**С.Эрдэнэболд:** Чуулган эхлэх гээд байгаа учраас маш товчхон явчихъя гэж бодож байна.

Би энэ мэдээлэл авахдаа Улсын Дээд шүүх чинь 12 эрэгтэй, 12 эмэгтэй байгаа юм байна гэж ойлголоо. Зөв үү? Л.Энхбилэг дарга аа? 13, 12.

Тэгэхээр одоо Э.Золзаяа шүүгч хэрвээ Улсын дээд шүүхийн шүүгч болчихвол 13, 13 болох юм уу?

Тэгээд ямар ч байсан юу яах юм байна шүү дээ. Ер нь жендэрийн хувьд маш урьд өмнө түүхэндээ байгаагүй хамгийн том үзүүлэлт болох юм байна.

Тэгээд эхлээд Э.Золзаяа шүүгч танд бас амжилт хүсье.

Одоо ингээд та бас зурагтаар гарч байгаа. Тэгээд юу гэж хэлэх гээд байна гэхээрээ Монголын иргэд энэ шүүхийн системийн шударга ёсны талбар дээр аягүй их гомдолтой байдаг, маш их итгэл алдарсан байдаг.

Тэгэхээр мэдээж англи-саксоны шүүхийн тогтолцоотой орнуудад шүүгчид нь маш их тийм олон нийтэд нээлттэй, ил тод, энэ шударга ёсны талаар уриалж байдаг. Тийм ээ.

Сүүлийн жилүүдэд Ром-Германы системтэй орнууд ч гэсэн шүүгчид нь, Дээд шүүхийн шүүгчид нь бас энэ манлайлах талбар дээр олон нийтэд шударга ёсны үнэ цэнийг ойлгуулах талбар дээр бас их ажилладаг болсон.

2021 оноос өгсүүлээд одоо 3 жилийн турш Нэгдсэн Үндэстний Байгууллагаас олон улсын эмэгтэй шүүгч болон шүүхийн салбарт ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн өдөр гээд өдөртэй болсон байгаа. Жил болгоны 3 дугаар сарын 10 бол эмэгтэй шүүгчдийн өдөр байгаа.

Тэгэхээр юу гэж хэлэх гээд байна гэхээрээ эмэгтэйчүүд шүүхийн салбарт ажиллах, эмэгтэйчүүд шүүхийн шийдвэр гаргах үйл явцад оролцох нь өөрөө ямар ач холбогдолтой байдаг вэ? Тэр тусмаа нийгэмд ямар үнэ цэн авчирдаг вэ гэдэг дээр хэд хэдэн нийтлэлүүд, тэр зүйлээр 3 дугаар сарын 10-ны үед бас гарч байсан.

Тэгэхээр энд дандаа олон улсын хөгжил өндөртэй орнуудын л түүхүүд яваад байдаг. Монгол энд сураг ч үгүй байдаг.

Тийм учраас юу гэж хэлэх гээд байна гэхээрээ энэ шүүхийн салбар дахь эмэгтэйчүүдийн манлайлал, тэгээд дээрээс нь шударга ёсыг хамгаалах, сахих үйл ажиллагаанд энэ шүүхийн нэр хүндийг, шүүгчийн нэр хүндийг, ялангуяа эмэгтэй шүүгчдийнхээ нэр хүндийг өндөрт өргөж яваарай гэдэг үг хэлье.

Тэгээд таны энэ өөрийгөө үнэлсэн үр чадварыг ингээд харахаар та нийт 34 үнэлгээнээс бүгд дээр нь та 3 буюу одоо сайн гэсэн үнэлгээг өөртөө өгсөн байна. Энэ өөрийгөө дүгнэж байгаа үнэлгээ.

Тэгээд эндээ итгэл үнэмшилтэй байгаарай. Энэ бол аймаар том зориг шүү. 1, 2, 3 гэсэн үнэлгээнээс Та бүх үнэлгээгээ дандаа дүүргэж хамгийн сайн дээр нь өгсөн байна.

Тэгэхээр итгэлтэй байгаарай гэж хэлмээр байна.

Тэгээд нэгхэн асуулт маш товчхон асуучихъя. Хүмүүс шударга ёсыг янз бүрээр хэлдэг. Та одоо Дээд шүүхийн шүүгч болох гэж байгаа хүн маш товчхондоо шударга ёс гэж юу вэ?

**Д.Цогтбаатар:** Маш товчхон хариулаад хурлаа түр завсарлахгүй болохгүй байна. Манайх нөгөө гишүүд ирцдээ орохгүй бол. Тийм. Санал хураахгүй шүү дээ. Тийм. Үг хэлнэ шүү дээ.

Үүнийг процедураараа явуулахгүй бол болохгүй. Зүгээр очоод бүртгүүлчхээд хүрээд ир. Манайхан. Тийм.

Ер нь ингэе. Манайхан буцаж ирээрэй. Энэ хүнийгээ бас хүндэтгээрэй. Тэгээд хариулъя. Түр хүлээж байгаарай.

Хурлаа эхлүүлбэ. 3 дугаар микрофоныг өгье. Түрүүнд шударга ёс гэж юу ойлгож байгаа вэ гэдэг асуултад хариулахаас хурлаа сэргээе.

**Э.Золзаяа:** Гишүүний асуултад хариулъя.

Шударга байна гэдгийг хамгийн богиноор хариулж өгнө үү гэсэн. Хурдан.

Тэгэхээр зөв байна л гэж хариулъя. Зөв байх ёстой.

Шударга ёсны өөрийн хэмжүүр байгаа. Хуульд онолын хүрээндээ шударга ёсыг агуулгын хувьд хуульчилчих юм шударга ёс бүрдэж байна гэдэг зарим хэлбэрийн хувьд шаардлага хангаж байвал шударга ёс бүрдэж байна гээд.

Энэ онолын хоёр асуудлын хүрээнд хууль тогтоогч нар шударга ёсныхоо хэмжүүрийг агуулгын болон хэлбэрийн хувьд барьж хуулийг баримталж байгаа.

Шүүгч хэргийг хуульд заасны дагуу хуулийг хэрэглэж хэргийг шийдвэрлэдэг.

Хэрэг маргааныг шийдвэрлэхдээ Үндсэн хууль, хуульд нийцүүлнэ. Хууль нь Үндсэн хуулийг нийцэхгүй байна гэж үзэх юм бол хуулийг хэрэглэхгүй байх ийм эрх хэмжээтэй. Ингэж хариулъя даа.

**Д.Цогтбаатар:** Одоо нэр дэвшигчтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье.

Х.Тэмүүжин гишүүнийг хэлнэ гэснээр оруулаад бүртгэчихье. Х.Тэмүүжин гишүүнээр тасаллаа. Х.Баасанжаргал гишүүний микрофоныг өгье.

**Х.Баасанжаргал:** Улсын Дээд шүүхэд нэр дэвшиж байгаа танд амжилт хүсье.

Маш их нэр төрийн хэрэг. Тэгээд манай хуульчдын хувьд ч гэсэн Улсын дээд шүүхийн шүүгчдийг бид хамгийн том карьераас гадна гол алтан гадас, маш их итгэл найдвар тээдэг.

Шүүхэд итгэх иргэдийн итгэлийг өсгөх тал дээр бусад хуульч нартайгаа, түрүүн ярьж байсан. Яг Хуульчдын холбоод дээр идэвхтэй ажилладаг гээд. Манайхан Дээд шүүх рүү очихоороо бас Хуульчдын холбооныхоо ажлыг больчихдог тал байдаг.

Тэгэхээр шүүхэд итгэх иргэдийн итгэлийг хадгалж явах, цааш нь улам өндөрт өргөхийн тулд бусад хуульчдын бүлэг, хуульчдын энэ үйл ажиллагааг бас идэвхтэй манлайлж ажиллаасай гэж хүсэж байна. Тэгээд танд амжилт хүсье.

**Д.Цогтбаатар:** С.Эрдэнэболд гишүүний микрофоныг өгье.

**С.Эрдэнэболд:** Би таныг түүхийг судалж байхад Орост сурч байхдаа 170 цаг философи үзэж байсан юм байна лээ.

Технологийн хичээл 500-аад цаг үзэж байсан юм байна лээ.

Тэгээд ерөнхийдөө Орост сурч байсан болон Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд сурсан материалуудыг харсан.

Тэгээд ер нь яг саяын манай Х.Баасанжаргал гишүүний хэлсэнчлэн хүмүүс шударга ёсны хүсэмжлэл маш өндөр байгаа. Та үүнийг маш сайн мэдэж байгаа.

Дээрээс нь та бас 2 охинтой юм билээ. Ер нь ингээд насных нь байдлыг харахад ч гэсэн бас л одоо яг энэ залуучуудын өмнө тулгамдаж байгаа асуудал, өсвөр насны хүүхдийн өмнө тулгамдаж байгаа асуудал гээд маш олон зүйл байдаг.

Тэгэхээр ерөнхийдөө аль болохоор хэдий богино хугацаанд танилцуулга материал ирсэн ч гэсэн бид нарт нөгөө шүүгч гэнгүүт л нэг тийм тусдаа бид нараас тусдаа хүн шиг маш их боддог. Гэхдээ ялгаа байхгүй энэ нийгэмд бид нар хамтдаа ингээд л одоо зах зээлийн эдийн засаг, тэгээд л өөрчлөн байгуулалт гээд л явсаар байгаад л өдий зэрэгтээ хүрсэн байгаа.

Тэгэхээр ер нь ийм шинэ тутам энэ амьдралын хэв маяг, энэ технологи эрчтэй явж байгаагийн энэ хэрээр энэ шударга ёс гэдэг ойлголт хуучин онолын хувь тогтоодгоос илүүтэйгээр аягүй одоо нөгөө тийм хэрэглээний болж хувирсан. Ялангуяа одоо ингээд аймшигтай зүйлс энэ өсвөр насны хүүхдүүдийн дунд л тулгамдаж байгаа амиа хорлолт, тэрний дийлэнх нь эрэгтэйчүүд байгаа ч гэдэг юм уу. Ингээд маш олон зүйлүүд байгаад байгаа.

Тэгэхээр ер нь ингээд энэ “женерэйшн зэд” гээд энэ сэтгэхүйн хувьд шал өөр үеийн хүмүүс орж ирж байна. Энэ нийгэмд. Ингэхийн хэрээр шинэ үеийн хүмүүс орж ирэхийн хэрээр энэ шударга ёсыг үзэх, харах, энэнээс

хүлээх хүлээлт нь ч гэсэн ингээд маш динамик болж эхэлсэн.

Тэгэхээр ер нь хэлэх гээд байгаа санаа маань та өөрөө бас технологи суурьтай мэргэжлийн хүн учраас энэ технологийн хурд хүний хөгжил хоёр чинь хоорондоо хоорондоо шүтэлцэж явдаг учраас хүний үнэт зүйл, хүний үнэ цэний асуудал ч гэсэн бас энд маш шинэ тутам сэргээгдэж байгаа.

Одоо ойрын жилүүдэд бид нар чинь одоо ингээд Марс гарагт 2030-аад онд хүн төрөлхтөн буух гэж байна. 100 жилийн дараа гээд технологи маш өөр болно.

Тэгээд энэ нь хүмүүсийн үнэт зүйл дээр ингээд маш ийм шинэчлэлт явагдаад байна. Тэгэнгүүт ингээд харж байхад энэ манай ялангуяа энэ шүүхийн нэг хардалт шүү дээ. Одоо улс төрчдийн ч юм уу, шүүгчдийн гаргаж байгаа шийдвэрүүд нь олон нийтийн энэ одоо популизм. Дээрээс нь энэ хэт туйлшралыг харгалзан үзэж шийдвэр гаргаад байгаа юм шиг ийм хардалтууд яваад байгаа. Сүүлийн үед.

Яг цэвэр одоо хуулийн гэхээсээ илүүтэйгээр хуульд заагдсанаар одоо энэ хуулийг хэрэглэх гэхээсээ илүүтэйгээр маш их тийм одоо “байст” гэж хэлдэг шүү дээ. Тийм ээ. Улс төрийн сүүдэр нөлөө, улс төрчдийн сүүдэр нөлөөнд автчихсан юм шиг шийдвэр гаргаад байгаа учраас Улсын дээд шүүхийн шүүгч зөвхөн Э.Золзаяад төдийгүй бусад одоо шүүгчид маань ч гэсэн бас энэ дээр энэ соён гэгээрүүлэх чиглэлийн, хүмүүстээ одоо энэ мэдээлэлжүүлэх чиглэлийн, ялангуяа энэ хуулийн асуудалд орчхоод шүүх дээр очоод хүн ингээд дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу болдог биш асуудалд орохоосоо өмнө бас энгийн ийм соён гэгээрлийн

чиглэлийн юм Дээд шүүхээс явдаг байвал.

Эртээр Хууль зүйн сайдад бас үүнийг хэлсэн. Манай Д.Цогтбаатар дарга хүн бүхэн өөрөө хуулиа биелүүлэх ёстой, мэдэх ёстой гэж хэлээд байгаа. Тийм ээ.

Тэгэхдээ бид нар ч гэсэн энэ дээр энэ хуулийг болон одоо энэ шударга ёсны чиглэлийн мэдээ мэдээллүүдийг маш сайн хүргэж байгаасай гэж бодож байна.

Тэгээд түрүүн дахиад хэлсэнчлэн бараг эмэгтэй шүүгчдийн маань Дээд шүүхийн тоо эрэгтэйтэйгээ бүр тэнцээд ирж байна. Энэ бараг түүхэн маш том үйл явдал гэж харж харж байна.

Та одоо ингээд Ерөнхийлөгч таныг таныг одоо ингээд томилсноороо та одоо шинэ хуудас нээж байна гэсэн үг шүү дээ. Монголын дээд шүүхийн салбарт эмэгтэйчүүдийн жин дарж байгаа маш том түүхийн хуудсыг нээж байна. Маш том итгэл найдвар гэсэн үг шүү гэж. Тэгээд танд амжилт хүсье.

**Д.Цогтбаатар:** Х.Тэмүүжин гишүүний микрофоныг өгье.

**Х.Тэмүүжин:** Би энэ протоколд хоёр юм тэмдэглэж үлдээх гэж байгаа юм.

Нэгдүгээрт нь, Монгол Улс өмнөх 70 жил хувийн эрх зүй гэж огт байхгүй байсан.

Тэгээд сүүлийн 30 жилийн энэ үйл явдал дотор бид хувийн эрх зүйг бойжуулж бий болгох гэж оролдож байгаа.

Тэгээд шүүхийн маш олон шийдвэрүүдээр энэ хувийн эрх зүй өөрөө хязгаарлагдаж байгаа. Үзэл санааны хувьд, онолын хувьд, арга зүйн хувьд гээд олон зүйл дээр.

Яагаад гэвэл манай яг энэ хувийн эрх зүй буюу худалдаан дээр, гэрээн дээр, энэ олон улс дамжин хийгдэж байгаа гэрээ хэлцлүүд дээр гэх мэтчилэн. Эсвэл энэ банк, санхүүтэй холбоотой нарийн түвэгтэй үйл ажиллагаан дээр гэх мэтчилэн мэдлэг мэдээлэл жоохон хомс байгаа.

Түүнээсээ болоод бизнесийн маш олон үйл ажиллагаа шүүхийн болон хуулийн байгууллагуудын үйл ажиллагаагаар хязгаарлагдаад урагшаа тэлж өгөхгүй байна гэдэг гомдол санал байгаа.

2002 онд хувийн эрх зүй дээр том дэвшил иргэний эрх зүйн шинэчилсэн хувилбараар явсан.

Тэгээд энэ чинь одоо 22 жилийн өмнө болж байна гэсэн үг. Одоо яах аргагүй нийгмийнхээ өсөлт, хэрэгцээ шаардлагаас бас хоцрогдоод явж байгаа. Энэ хоцрогдлыг нэг талаасаа хууль тогтоогчид засах ёстой. Нөгөө талаасаа шүүхийн практик дээр бас засагдах ёстой.

Тэгээд иргэний эрх зүй дээр очиж байгаа шүүгчээс хүсэж байгаа зүйл бол Дээд шүүх тэр дундаа, зүгээр нэг хэрэг маргааныг үйл баримтаар нь шийдвэрлэхээс илүүтэйгээр илүү онолын, хуулийн хэрэглээний тайлбаруудаар дамжуулж тэлэх учраас энэ чиглэлээрээ дэвшил гаргаж ажиллаарай гэж хүсэж байгаа юм.

Түрүүний би жишээ дурдсан. Дэлхийд хоёрхон кейс байдаг гэж. Нэг нь Италийнх.

Араб ертөнцийн тухай нэг хүн судалгаа хийгээд ном бичсэн байгаа юм. Тэгсэн чинь нэг хүн надаас илүү судалгаа ч байхгүй. Миний нэрийг дурдаагүй учраас энэ ном одоо хамгийн дэвшилттэй байж чадахгүй гэж шүүхэд хандсан байгаа байхгүй юу.

Тэгээд Италийн шүүх маргааныг хүлээж аваад маргаан үүсгэсэн боловч шийдвэр гаргаагүй.

Яагаад гэвэл хэн нэгэн ямар салбар дээр хамгийн мундаг нь гэдгийг шүүх тогтоох ямар ч боломжгүй. Шинжлэх ухаан буюу мэдлэгийн салбар далай шиг дуусахгүй. Хүний мэдэж байгаа нь өчүүхэн хэсэг. Академик эрх чөлөө. Тэр дуусахгүй мэдлэгийг самардаж байгаа учраас энэ процессыг энд төгсөж байна. Энэ хамгийн төгс төгөлдөр гэдэг хуулийн системээр шийдэж болдоггүй юм гэдгээр Италийн шүүх шийдвэрээ гаргалгүйгээр зогсоосон байгаа байхгүй юу.

Монгол Улсад яг үүнтэй адилхан хүн хоцрогдсон уу, хоцрогдоогүй юу гэдэг гомдол санал гаргаж байсан.

Монгол Улсын шүүх шийдсэн. Шийдсэн шүүгч нь ч бараг та өөрөө байх.

Хүнийг хоцрогдсон, хоцрогдоогүй гэдэг. Тухайлбал, Эрүүгийн хууль дээр гудамж талбайд зураг зурах нь вандализм буюу одоо хорлон сүйтгэх гэмт хэрэг гэж социалист аргаар бичиж байгаа хүнийг энэ хоцрогдож байна. Гудамж, талбай дээр, хашаан дээр зураг зурах чинь орчин үед урлаг тал руугаа хөгжчихсэн.

Энэ бол залуучуудын үзэл бодлоо илэрхийлэх нэг шинэ төрлийн хэлбэр болсон. Хэрвээ буруутгагдах бол бусдын эд өмчийг сүйтгэсэн гэдэг хэлбэрээр л буруутгагдах байх.

Түүнээс энэ бол вандализм гэж байж болохгүй гэдэг ийм хууль тогтоогчдын хүрээнд гарсан маргаан дээр хэн нэг нь би одоо хамгийн мундаг салбарын мэргэжилтэн. Намайг хоцрогдсон гэж хэллээ гээд шүүхэд гомдол гаргахад тэрийг нь аваад шийдэж байсан тохиолдол Монголд байгаа байхгүй юу.

Тэгээд ийм байдлаар шүүх өөрөө хоцрогдлыг, шүүх өөрөө дэвшилтэт бус үзэл санааг, шүүх өөрөө цаг үеийн өнгөрсөн түүхийг буцааж сэргээх хэрэгсэл болох юм аюултай.

Тийм учраас Дээд шүүхийн шүүгч болж байгаагийн хувьд цаг ямагт дэвшилтэт үзэл санааны дунд алхаарай. Цаг үеэ мэдэрч ирээдүй цагийг төлөөлж алхаа цохиорой. Шийдвэрийн үндэслэлүүд чинь илүү хүний эрхийн, шударга ёсны, бас хөгжлийн алхам байгаарай.../минут дуусав/

**Д.Цогтбаатар:** Гишүүд саналаа хэллээ.

Би хоёр санал хэлчихье гэж бодож байна. Э.Золзаяа шүүгч ээ.

Мэдээж энэ улс төрийн механизмаар Та анх орж байгаа байх.

Тэгэхээр бага зэргийн сандралтай байхыг үгүйсгэхгүй. Та Дээд шүүхийн шүүгч болж байгаа хүн хуулиа мэдэж байгаа хүний хувьд хэний ч өмнө итгэлтэй, өөрийнхөө байр суурийг,

хуулийнхаа байр суурийг хатуу барьж байх нь зөв өө гэж бодож байна.

Тийм учраас энд улс төрчидтэй ярьж байхад нэг их сандраад хэрэггүй. Хуулиа л барьж ярьж байгаа бол тэрийгээ тодорхой хэлэх хэрэгтэй.

Би яагаад үүнийг хэлж байна гэхээр түрүүн Х.Тэмүүжин гишүүн асуусан л даа.

Улс төрийн хамтын шийдвэр. Энэ их ноцтой асуудал учраас би онцолж ярьж байгаа юм. Улс төрийн хамтын шийдвэр дээр шүүх шийдвэр гаргаад байна гээд. Нээрээ улс төрийн хамтын шийдвэр, улс төрийн чанартай шийдвэр дээр ард түмэн л дараа нь дүн тавьдаг юм. Сонгуулиар. Буруу шийдвэр гаргасан бол ордноос хөөж явуулна. Дахиж тэр шийдвэр гаргах боломжийг нь ард түмэн мандат өгч эрх өгдөггүйгээр шийтгэж байгаа юм.

Түүнээс тэрийг шүүх барьж аваад шийднэ. Ялангуяа тэр процессоороо хуулийн дагуу зөв гарчихсан шийдвэр дээр тэр зөв бурууг нь ард түмэн л шийднэ. Шүүх шийдэхгүй.

Манайд ийм тохиолдлууд гарсан байхгүй юу. Үүнийг таслан цогцлоох ёстой. Би нөгөө аль ч шүүгчдэд хэлээд байгаа. Даргын захиасаар явдаг газар биш шүү. Шүүх бол. Шүүх бол хуулийн дагуу л явдаг. Ямар ч дарга тэрний хажуугаас орж ирж ямар нэгэн нөлөө үзүүлэх ёсгүй шүү гэдгийг анхаарч ажиллаарай. Тэр дээрээ Та нар зоригтой байгаарай гэж хэлмээр байгаа юм.

Тэгээд та түрүүн тэр юун дээр хариулахдаа ингэж байна л даа. Тэр хамтын шийдвэр дээр гэсэн бас хуульч хүн болохоор яах аргагүй зайлшгүй



оролцох хэлбэрийг сонгож байгаа байхгүй юу.

Тэр нь тендерийн асуудал дээр процесс талаасаа би оролцоно гээд. Эрх зүйн хувьд энэ чинь үнэхээр юунд нийцэхгүй хариулт орж ирж байна шүү.

Яагаад гэвэл тендер улс төр биш байхгүй юу. Тендер эхнээсээ дуустал хууль байхгүй юу. Энд чинь хүн улс төрийн асуудал ярьж байна шүү дээ.

Зүгээр үүнийг чинь би юу гэж цаашаа уншиж байна гэхээр орж байгаагаа зөвтгөх гэж байгаа хувилбар тайлбарлах гээд байгаа юм шиг. Үүнийг энд хүмүүс уншиж чадахгүй гэж бодож байгаа юм шиг ингэж хандаж болохгүй.

Улс төрийн тэр шийдвэрт харин оролцоод байгаа нь зохимжгүй юм гээд. Шүүгч хүн зохимжтой, зохимжгүй тухай ярихгүй. Хуульд нийцэж байгаа юу, үгүй юу тухай ярина.

Нийцэхгүй байгаа юм бол шууд л угаасаа зохимжгүй. Тэр дээр ямар нэгэн зохимжийн субъектив хандлага байж болохгүй.

Сая ч гэсэн энэ асуултад шударга ёс гэж юу вэ гээд тэгэхэд би таныг хуулийг барих л гэж хариулах байх гэж бодсон. Шүүгч хүн. Түүнээс зөв байх гэж.

Тэгэхээр хуулийн гадуур зөв юм байх гээд байгаа бол наадах чинь жинхэнэ том аюул үүсгэнэ.

Шударга ёс чинь хуулийг дээдэлнэ гээд “rule of law” гэдэг чинь юуг дээдэлдэг вэ гэхээр зөв буюу шударга юм чинь хуульд шингэчихсэн байгаа учраас тэрийг дээдэлж байгаа юм.

Түүнээс гадна зөв шударга юмыг хэн нэгэн тогтоох. Хэрэв тэнд зохицуулагдаагүй байгаа бол тэрийг энд хууль тогтоогчид гаргаад явна. Түүнээс энэ нийгэмд байж байгаа шударга ёсны дээд юм чинь өнөөдөртөө юу гэвэл тэр хуулиа л сахих асуудал шүү.

Тэгэхээр үүнийгээ. Энэ яагаад гэвэл сэтгэлгээний өөрөө суурь асуудлуудын индикатор яг энд асуулт дунд гарч ирж байгаа учраас. Тэгээд үүнийгээ та нар маань сайн чанд сахиж барьж байгаарай л гэж би захимаар байна.

Нэг зүйлийг хэлмээр байна. Шүүх бол ерөөсөө л төр гэдэг гурван үндсэн баганатай. Хууль тогтоох байгууллага, хууль хэрэгжүүлэх байгууллага буюу гүйцэтгэх засаглал. Тэгээд шүүх гэсэн гурван л багана байгаа.

Харин энэ дээр би Байнгын хорооныхоо гишүүдэд хандаад хэлэхэд эртээд тэр төсвийн юун дээр дэмжээд өгсөнд би их баярлаж байгаа.

Яагаад гэвэл энэ хүмүүсээс шударга ёсыг нэхэхийн тулд төр өөрийнхөө хийх үүргийг заавал биелүүлэх ёстой. Энэ чинь сонголтын асуудал биш байхгүй юу. Төсвийг нь заавал баталж өгөх ёстой. Тэгэхгүй төсвийг нь батлаагүй эд нарыг бүх юмаар нь хомсдуулчихсан, байргүй байлгачхаад тэгээд дараа нь шударга ёс нэхнэ гэдэг бол өөрөө шударга бусын дээд туйл байхгүй юу. Ажиллах нөхцөлөөр нь хангах ёстой.

Энэ дээр манай байнгын хорооныхон ч гэсэн цаашдаа хатуу байр суурь барьж байгаасай гэж бодож байгаа.

Би үүнийг юутай холбогдуулж хэлж байна гэхээр одоо жишээлбэл соёлын төвүүд орж ирэхэд би хөдөө орон нутагт соёлын төвийг дэмжинэ. 100 хувь дэмжинэ.

Тэгэхдээ би сая яагаад шүүх төрийн үндсэн гурван баганын нэг гэж хэлж байгаа гэхээр соёлын асуудал төрийн оршин тогтнох эсэхийг шийддэг гурван баганын чинь нэг биш байхгүй юу.

Хэрэв энэ дээр сонголт байгаа бол шүүх дээр нь төсвийг нь тавьж өгч байх ёстой. Тэгээд дараа нь тэр соёлын юунуудыг би үгүйсгэж байгаа биш.

Тэгэхдээ хэрэв эрэмбэ барих юм бол энэ чинь ийм л асуудал байж байгаа.

Тэгээд энэ тал дээрээ ч гэсэн цааш цаашдаа ер нь манайхан бас анхаарч

ажиллах ёстой болов уу. Энэ асуудлыгаа ч гэсэн манай Шүүхийн ерөнхий зөвлөл цаашдаа тавьж явж байгаарай.

Үүнийг л хэлмээр байгаа юм.

Э.Золзаяа шүүгчтэй танилцлаа.

Байнгын хороогоор санал хураахгүй зөвхөн танилцах л үүрэгтэй.

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг танилцуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг танилцуулна.

Байнгын хороо хэлэлцэх асуудлаа хэлэлцэж дууссан тул Байнгын хорооны хуралдаан өндөрлөлөө. Баярлалаа. /алх цохив/

Хуралдаан 1 цаг 14 минут үргэлжилж, 10 цаг 30 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,  
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

**Ц.АЛТАН-ОД**